


БАТЛАВ

ЗАХИАЛАГЧ:

ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ

ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Н.ЭРДЭНЭБАЯР



НИЙЛҮҮЛЭГЧ:

АР-ЖАНАР ХХК-ИЙН

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Б.НАРАНЦЭЦЭГ



“Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төвд”

Бар кодны цаас нийлүүлэх гэрээ

2016 оны 2 сарын 18

Улаанбаатар хот

Нэг талаас “Цус Сэлбэлт Судлалын Үндэсний төв” (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас “Ар Жанар” ХХК (“цаашид нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2016 оны 2 дугаар сарын 18-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

Нэг: Нийтлэг үндэслэл

- 1.1. Монгол улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдох харилцааг зохицуулахад энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- 1.2. Захиалагч 2 төрлийн Бар кодны цаасыг **23,077,200** (хорин гурван сая далан долоон мянга хоёр зуун) төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
- 1.3. Гэрээний нийт дүн **23,077,200** төгрөг байна. Төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
- 1.4. Нийлүүлэгч 2 төрлийн Бар кодны цаасыг 2016 оны 3 дугаар сарын 18-ны дотор нийлүүлж хүлээлгэн өгнө.
- 1.5. Дор дурьдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно. (Цаашид гэрээний баримт гэх) Үүнд:
 - А. Гэрээ байгуулах тухай мэдэгдэл
 - Б. Үнийн хуваарь
 - В. Гэрээний тусгай нөхцөл
 - Г. Гэрээний ерөнхий нөхцөл
 - Д. Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь

Гэрээ нь энд дурьдсан бараа нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний

бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурьдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

ХОЁР. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

2.1. Захиалагч нь 1.4-т дурьдсан хугацаанд нийлүүлэгдсэн барааг хүлээн авч, хүлээн авсан тухай баримт бичиг болон нийлүүлэгчийн нэхэмжлэлийг үндэслэн 20 хоногийн дотор нийлүүлэгчийн данс руу шилжүүлэх үүрэгтэй.

2.2. Захиалагч нь гэрээгээр тохиролцсон төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд нэхэмжилсэн үнийн дүнгийн 0,5 хувьтай тэнцэх алдангийг хэтрүүлсэн долоо хоног тутамд нийлүүлэгчид төлөх үүрэгтэй.

2.3. Захиалагч нь нийлүүлэгчийн нийлүүлсэн бараа техникийн тодорхойлолтын шаардлага хангаагүй, эсвэл нийлүүлэгч нь гэрээний бусад үүргээ биелүүлээгүй тохиолдолд нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг бүхэлд нь болон хэсэгчлэн цуцлах эрхтэй.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Нийлүүлэгч нь гэрээний бүх нөхцөл, техникийн тодорхойлолтонд нийцсэн барааг нийлүүлэх үүрэгтэй.

3.2. Барааны шошго нь тендерийн материалд заасны дагуу англи хэл дээр бичигдсэн байна.

3.3. Нийлүүлэгч нь барааг шаардлагын дагуу зөв тээвэрлэн хүргэх нөхцөлийг хангах асуудлыг бүрэн хариуцана.

3.4. Нийлүүлэгч нь барааны тоо хэмжээг дутаах, нийлүүлэх хугацааг хоцроох асуудал гаргасан тохиолдолд 7 хоногт 0,5%-ийн алдангийг захиалагчид төлнө.

ДӨРӨВ. ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

Гэрээ нь нийлүүлэгч барааг захиалагчид хүлээлгэн өгч, төлбөрийг дансаар хүлээн авч дуусах хүртэл хүчинтэй байна.

ТАВ. БУСАД ЗҮЙЛ

5.1. Талууд гэрээнд холбогдох асуудлаар албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

5.2. Гэрээ хэрэгжүүлэхтэй холбоотой үүссэн аливаа маргааныг талууд зөвшилцлийн журмаар шийдвэрлэх ба зөвшилцөх боломжгүй болсон тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

Уг гэрээ нь монгол хэл дээр 3 хувь хийгдсэн ба талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний

Төвийн Ерөнхий нягтлан бодогч Д.Гүнжээ

Хаяг: Сүхбаатар дүүрэг, Энхтайваны
өргөн чөлөө-13, С.Зоригийн гудамж

Утас: 326504, 312857, Факс: 976-11- 312857



НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ :

Ар Жанар ХХК-ний
Менежер Б.Мөнгөншагай

Хаяг: Сонгино хайрхан дүүрэг,
17-р хороо

Утас: 70171710 , 98118654

БАРАА НИЙЛҮҮЛЭХ ХУВААРЬ БАР КОДНЫ ЦААС

Код	Бүтээгдэхүүний нэр	Эмийн олон улсын буюу ерөнхий нэршил	Эмийн хэлбэр	Савлалтын хэмжээ	Шаардагдаж буй хэмжээ	Нийлүүлэлтийн хуваарь
1	ЦЦБ хаяг	Zebra HC10000688 prime blood bag 8000 T4 4"4".8" outer diameter, 1100 labels/roll, 4 rool pack	Туслах материал	Хайрцаг /хайрцаг дотор 4 боодол, нэг боодолд 1100 ширхэг/	100 боодол буюу 25 хайрцаг	2016-03-18
2	Жижиг цусны хүүдий, хуруу шилэнд наах хаяг	/Zebra 10010038 Z-select 4000 D direct terminal paper labels, 1,25 inch*1,000 inch, 5 inch outer diameter, 2340 labels/6 roll pack	Туслах материал	Хайрцаг /хайрцаг дотор 6 боодол, нэг боодолд 2340 ширхэг/	210 боодол буюу 35 хайрцаг	2016-03-18

Захиалагчийг төлөөлж :
 Цус Сэлбэлт Судлалын Үндэсний
 Ерөнхий нягтлан бодогч
 Д.Гүнжээ
 Нөөц хангамж үйлчилгээний тасгийн эрхлэгч
 Ч.Далайцэрэн

Нийлүүлэгчийг төлөөлж :
 Ар жанар ХХК-ийг
 Менежер
 Б.Мөнгөншагай.....



МОНГОЛ УЛСЫН ГАДНА ҮЙЛДВЭРЛЭГДСЭН БӨГӨӨД ИМПОРТООР ОРЖ ИРЭХ БАРААНЫ ҮНИЙН ХУВААРЬ
(Б ангилал)

Огноо: 2016.02.18

НТШ-ын дугаар:

Тендерийн урилгын дугаар: 2016 он 02

БАР КОДНЫ ЦААС

1	2	3	4	5	6
№	Барааны тодорхойлолт	Гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	ЦЦБ-ний хаяг	ANSN packing Co.Ltd Shenzhen, Хятад	100 боодол буюу 25 хайрцаг	182,640	18,264,000
2	Жижиг цусны хүүдий, хуруу шилэнд наах хаяг	ANSN packing Co.Ltd Shenzhen, Хятад	210 боодол буюу 35 хайрцаг	22,920	4,813,200
Нийт үнэ /төгрөг/					23,077,200